

БАТЛАВ.
“УБЦТС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАЯРСАЙХАН



БАТЛАВ.
“ЭРЧИМ ӨГИЙ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

М.ГЭРЭЛЧУЛУУН

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН 0-73.1 КМ ХЭСГИЙН ӨРГӨТГӨЛИЙН ТРАССТ ОРСОН ЦШС-НИЙ ӨӨРЧЛӨЛТ, НАРНЫ ХУРИМТЛУУРТ ГЭРЭЛТҮҮЛЭГ УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № 2019/330

2019 оны 08 сарын 19

Улаанбаатар хот

Нэг талаас “УБЦТС” ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “ЭРЧИМ ӨГИЙ” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН 0-73.1 КМ ХЭСГИЙН ӨРГӨТГӨЛИЙН ТРАССТ ОРСОН ЦШС-НИЙ ӨӨРЧЛӨЛТ, НАРНЫ ХУРИМТЛУУРТ ГЭРЭЛТҮҮЛЭГ угсралтын ажлыг (цаашид “ажил” гэх) 230,000,000.0 (хоёр зуун гучин сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: 230,000,000.0 (хоёр зуун гучин сая төгрөг. Санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:
 - А. Гэрээ байгуулагдаснаас хойш гэрээний үнийн дүнгийн 30 хувийн үнийн дүнгийн урьдчилгаа төлбөр олгох,
 - Б. Ажил дууссаны дараа техникийн болон улсын комиссын акт баталгаажсанаар чанарын баталгааны барьцаа хөрөнгийг үлдээж үлдэгдэл гэрээний үнийн дүнгийн 65 хувийн санхүүжилтийг олгоно.
4. Гүйцэтгэгч УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН 0-73.1 КМ ХЭСГИЙН ӨРГӨТГӨЛИЙН ТРАССТ ОРСОН ЦШС-НИЙ ӨӨРЧЛӨЛТ, НАРНЫ ХУРИМТЛУУРТ ГЭРЭЛТҮҮЛЭГ угсралтын ажлыг уг ажлын зураг төслийн дагуу гүйцэтгэж 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдөр эхэлж, 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;


Гэрээний ерөнхий нөхцөл;
Зураг төсөл,
Ажил гүйцэтгэх хуваарь,
Бусад шаардлагатай баримт бичиг;

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Нийтлэг үйл ажиллагаа
эрхэлсэн дэд захирал

 О.Отгонбаяр


Санхүү бүртгэлийн хэлтсийн
дарга

 О.Ариунболд

Хангамж үйлчилгээний
албаны дарга

 Ш.Оюунчимэг

Хуулийн мэргэжилтэн
Ц.Энхцэцэг


Утас: 342420-129
Факс: 341671
Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р
хороо
Чингисийн өргөн чөлөө-45.

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Н.Гэрэлчулуун

Утас: 88110359, 88119941
Факс:
Хаяг: Баянгол дүүрэг, 5-р
хороо, Эрдэнэт суварга төв
404 тоот.